



ᠴᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠵᠢ ᠬᠡᠣᠷᠭᠠᠨ ᠠᠨᠠᠵᠢ ᠬᠡᠣᠷᠭᠠᠨ
ᠶᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠵᠢ
ᠶᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠵᠢ ᠬᠡᠣᠷᠭᠠᠨ ᠠᠨᠠᠵᠢ ᠬᠡᠣᠷᠭᠠᠨ

ОЙЖУУЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Илтгэгч: Ш.Эрдэнэдаваа
Ойжуулалтын бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хот 2011.04.19



ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ ҮНДЭСЛЭЛ

- Монгол орны хувьд ойгоор бүрхэгдсэн талбай нийт нутгийн 8.26%-ийг эзлэх бөгөөд сүүлийн жилүүдийн цаг агаарын дулаарал, ойн түймэр, мод бэлтгэл хүний буруу үйл ажмллагаа, цөлжилт хуурайшилт зэрэг сөрөг нөлөөллийн улмаас ойн экосистем доройтон өөрчлөгдсөөр байна.
- Ойн сангийн мэдээнээс үзэхэд 2011 оны бадлаар ойн түймэрт өртөж, шатсан ой 1184,4 мян.га, ойн хөнөөлт шавжид нэрвэгдсэн, хатаж хуурайшсан талбай 95,6 мян.га мод бэлтгэсэн талбай 125,2 мян.га талбай.
- Цөлжилт, шар шороон шуурганы эсрэг мод тарьж арчилж ургуулах, хот суурин газрын ногоон бүсийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.



Ойжуулалт



Үрийн нөөц, аж ахуйг хөгжүүлэх




Өсвөр модыг хамгаалах




Мод үржүүлэг



Жимс, жимсгэний мод тарьж, ургуулах



Ойн зурвас байгуулах



Хот суурингийн ногоон байгууламж



Ойг нөхөн сэргээх ажлыг дараах чиглэлээр зохион байгуулж байна.

1. Зориудаар нөхөн сэргээх /үр, тарьц, суулгац тарьж ургуулах/
2. Ойг байгалиараа сэргэн ургахад туслах
3. Ойн зурвас, хамгаалалтын зурвас байгуулах.
4. Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн /Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1/

1. Зориудаар ойг нөхөн сэргээх

ажилд

Мод огтолсон талбай



Түймэрт болон ойн хөнөөлт шавжинд нэрвэгдэж ургах чадвараа алдсан ойд



Зориудаар ойжуулах ажил

Ойжуулалтын ажлыг ойт хээрийн бүсэд техник ашиглан шан татах болон гар аргаар талбар гарган шилмүүст модны тарьцаар /нарс, шинэс/ 1 га талбайд 2500-3000 ширхэг, говь хээрийн бүсэд навчит модны суулгацаар /улиас, бургас, хайлас, бусад/ 1 га талбайд 500-1500 ширхэг гар аргаар хөрс боловсруулан тарилтын ажлыг хийж байна. Тарилтын ажлын 90-95 хувийг хаврын улиралд 5 сард хийж байгаа нь тэр үеэр хур тунадас ороогүйгээс тарьсан тарьц, суулгацыг услахгүй байснаас хуурай хөрсөнд тэр




2. Ойг байгалиараа сэргэн ургахад

туслах

Ойд ургаж байгаа модны үрийг байгалиараа унаж сэргэн ургахад зориудаар туслан хөрсийг хуулах, ургамлан бүрхэвчийг устгаж, үр ургах нөхцлийг бүрдүүлэх





3. Ойн зурвас, хамгаалалтын зурвас байгуулах.



**Цөлжилт
явагдаж
байгаа**




**Тариалангийн
талбай хамгаалж
ойн зурвас
байгуулах.**

**/1 га талбайд 500-с доошгүй
навчит модны суулгац
ургуулах/**



Ногоон хэрэм хөтөлбөр

Ойн зурвас байгуулах ажлыг өргөжүүлэн Монгол улсын Засгийн газраас “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг батлан 30 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг хөтөлбөр нь 2005 онд батлагдаж баруунаас зүүн тийш 500 м өргөнтэй 3700 км Ойн зурвас байгуулах, түүний орчимд тариалан эрхлэн иргэдийн амьжиргаа дээшлэх нөхцөл бүрдүүлсэн.



Энэ ажлын хүрээнд





4. Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн

- ▼ Бүх нийтээр мод тарих өдрийг Ойн тухай хууль, Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүрийн 5, 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гарагт зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд хуулийн дагуу иргэн бүр 1, ААН байгууллага бүр 5-аас доошгүй модыг тарьж ургуулах зорилттой ажиллаж байна.

Бүх нийтээр мод тарих ажил







2010 оны байдлаар Улсын ХЭМЖЭЭНД:

- ▼ Улсын үрийн нөөцийн санд 762,7 кг үр
- ▼ 167 шихэг мод үржүүлгийн газарт 32,6 сая ширхэг тарьц суулгац ургаж байна.
- ▼ 5056 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.
- ▼ “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд 253 га ойн зурвас байгуулсан.
- ▼ Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд 1744.6 мод тарьж ургуулсан

Мод үржүүлгийн газарт сүүлийн 10 жилд ургуулсан тарьц, суулгац /сая.шир/



Ойжуулсан талбай /га/





Тулгамдаж буй асуудлууд

- ❖ Хаврын цочир хүйтрэл, зуны хэт халалтын улмаас модны үр жимсны боловсролт муудаж боргоцой үүсэх үедээ хатаж, давчаарч чанаргүй үр түүх магадлалтай болсон
- ❖ Хүний сөрөг үйл ажиллагааны улмаас тухайлбал ойгоос мод бэлтгэхдээ хяналт муутай байгаагаас үрийн мод үлдээхгүй, сорчилж огтлох нь байгалийн сэргэн ургахгүй байна.
- ❖ Хөрөнгө мөнгөний гачигдалтай байгаагийн улмаас мод үржүүлгийн газарт тарьц, суулгацны арчилгаа, усжуулалт, тарилт зэрэг нь энгийн гар аргаар хийгдэж байгаа учир ойжуулалтанд таригдаж буй тарьц, суулгацны чанар муу, стандарт хэмжээнд хүрэхгүй байна.
- ❖ Цаг агаарын өөрчлөлтийн улмаас ойжуулалтын тарилтын үед хур тунадас орохгүй тарьц, суулгац хатаж байна.
- ❖ Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлын нормативт зардал бага байгаагаас ойжуулсан талбайг хамгаалах, арчлах ажил орхигдож үр дүнгүй ажил болж байна.



Цаашдын зорилт:

- Ойн төлөв байдлыг дээшлүүлэх, үрийн түр болон байнгын хэсгүүдийг байгуулах, үрийн нөөцийг бий болгох
- Үрийн нөөцийн санг бүрдүүлэх шаардлагатай тоног төхөөрөм, техник хэрэгслээр хангах.
- Мод үржүүлгийн газруудыг тоног төхөөрөмжөөр бүрэн механикжуулах , аймаг бүрт тохирсон мод үржүүлгийн газруудыг шинээр байгуулах.
- Тарьц, суулгацыг хиймэл хөрс, бортогонд ургуулж, шилжүүлснээр ойжуулалтын зардалыг хэмнэж амьдралтын чанарыг дээшлүүлнэ.
- Ойжээулалт, нөхөн сэргээлтийн ажилд орчин үеийн техник технологийн дэвшилтэт бага оврын тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.
- Ойжуулалтын ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хувь хүний ажлыг дэмжих, урамшууллын системтэй болох үүрэг, хариуцлагийг өндөржүүлэх.
- Хот суурины нэг хүнд оногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, иргэд аж ахуйн нэгж байгууллагын оролцоог дээшлүүлэх.



Анхаарал тавьсан
та бүхэнд баярлалаа
